



“НЭЭЛТТЭЙ ГОВЬСҮМБЭР”

УЛААНБААТАР ХОТООС ОРОН НУТАГТ ШИЛЖИН
ИРЖ БУЙ ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



Хөтөлбөрийн агуулга



- **Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал**
- **Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**
- **Хөтөлбөрийн зорилго**
- **Хөтөлбөрийн зорилт**
- **Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**
- **Авч хэрэгжүүлэх арга хэмжээ**
- **Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**
- **Хэрэгжүүлэх хугацаа**
- **Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр**
- **Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт**





Хууль, эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

47 дугаар зүйл: ИТХ-д асуудал санаачлан оруулах

60 дугаар зүйл: Аймгийн Засаг даргын бүрэн эрх

60.1.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;

60.1.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;

60.1.3.аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

Монгол улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”,

Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай”

Улсын Их Хурлын 2021 – оны 106 тогтоол , “Шинэ сэргэлтийн бодлого”

Засгийн газрын 2022 хуралдааны 56 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих зорилгоор “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг боловсрууллаа.



Хөтөлбөрийн зорилго

Аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, ААН, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлогын зорилттой уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах замаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх.



Өнөөгийн нөхцөл байдал




Нийт хүн ам 18042

Эрэгтэй
8979
49.8 хувь



Эмэгтэй
9063
50.2 хувь



5265
өрхтэй



60.7 хувь



1.9 хувь



37.4 хувь

Дотоодын нийт
бүтээгдэхүүн **155,315.9** сая
төгрөг,
Нэг хүнд ноогдох ДНБ
6,311.4 мян. төгрөг,
Аймгийн ДНБ-ний дийлэнх
буюу **51.5** хувийг
үйлчилгээний салбар,
27.55 хувийг
аж үйлдвэр, барилгын
салбар,
20.9 хувийг ХАА-н салбар
эзэлж байна.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ

www.govisumber.gov.mn
+976 7054-3434

Амьдралын ая тухтай, цэвэр цэмцгэр, төрийн үйлчилгээ авахад хүндрэлгүй, залуу, эрч хүчтэй аймаг

Суурь дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг өргөтгөн, цэвэр усны хангамж, эх үүсвэр, найдвартай байдлыг бүрэн шийдвэрлэв.



Солонгос улсын Эксим банкны хөрөнгө оруулалтаар дулааны станц, Польш улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар цэвэрлэх байгууламж байгуулах ажлыг эхлүүллээ.

Аймаг, сумдын төвүүд эрчим хүчний шугам сүлжээ, олон улсын шилэн кабель бүрэн холбогдсон. Цахилгаан түгээх, дамжуулах хүчин чадлыг үе шаттай өргөтгөж байна.



Аймгийн төвийн гэр хорооллын өрх, нийтийн эзэмшлийн орон сууцны айл өрхийг цэвэр усны шугамд бүрэн холбож, хэрэглээний халуун, хүйтэн усаар тогтмол хангаж байна.



Зам харилцаа, дэд бүтэц бүрэн хөгжиж, улсын чанартай авто болон төмөр замтай холбогдсон, нийтийн тээврээр бүрэн хангагдсан.





ГОВЬСҮМБЭР АЙМАГ

Амьдралын ая тухтай, цэвэр цэмцгэр, төрийн үйлчилгээ авахад хүндрэлгүй, залуу, эрч хүчтэй аймаг

www.govisumber.gov.mn

+976 7054-3434

Орон сууцны хангамж сайн. Хэрэглээний халуун, хүйтэн ус, дулаан хангамжид бүрэн холбогдсон.

Аймгийн төв болон сумд, хөдөөгийн багууд үүрийн телефоны сүлжээ болон олон улсын шилэн кабельд холбогдсон, дэлхийн аль ч улс оронтой телефон болон интернэтээр харилцах боломж бүрдсэн.



Чанартай боловсрол

Сургууль, цэцэрлэгийн 1 ангид 29 хүүхэд суралцаж, улсын хэмжээнд өрсөлдөхүйц боловсролыг олгож байна. (Говьсүмбэр аймаг нь ЭЕШ-ын дундаж оноогоор улсын дунджаас 15 оноогоор илүү, 526 оноотой байна. Нийт төгсөгчид нь 100 хувь их дээд сургуульд элсэн ордог. ЕБС, СӨБ-ын сургалтын байгууллагын үнэлгээгээр улсын дунджаас дээгүүр үнэлэгддэг нь боловсролын чанар сайжирч байгааг харуулж байна. ЕБС-ын хамрагдалт 100 хувь, СӨБ-ын хамрагдалтаараа улсад тэргүүлдэг.

Эрүүл мэндийн байгууллагын ачаалал бага, чанар, хүртээмж сайн. Бүсийн хэмжээнд оношилгоо, эмчилгээг хийж байгаа.

Хавдрын эрт илрүүлэг, хими эмчилгээ, гемодиализын эмчилгээ болон орчин үеийн дэвшилтэт эмчилгээ, үйлчилгээг нэвтрүүлсэн. Техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.



**Улсын бүртгэлд
632 хуулийн этгээд
бүртгэлтэй.**

**Үүнээс
221 НДШ төлдөг**

**ХХК
389**

**Төсөвт байгууллага
58**

шашны байгууллага 4

Холбоо 101

Нөхөрлөл 15

ОНӨААТҮГ 5

Сан 4

**төрийн өмчит компани
1**

**Үйлдвэрчний эвлэлийн
байгууллага 9**

**Гадаад ХОХХК
4**

Хоршоо 42

**Төрийн байгууллагад 2072
Орон нутгийн өмчит
байгууллага 241**

**Төрийн өмчи хувьцаат
компани 594**

**Хувийн хэвшил
2601**

Нийт 5508 иргэн ажиллаж байна.

ХХҮГ –т бүртгэлтэй 145, төрийн албанд 71 сул оронтоо байна.

Газар тариалан, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт 364 сул орон тоо байна.



Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

➤ Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бүс нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

➤ Аймаг, орон нутагт шилжин ирж ажиллаж амьдрах, үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсч болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож тусгахыг эрмэлзэн мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилсан, хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

➤ Хөтөлбөрийг иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх

Хөтөлбөрийн зорилт



Хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлэх.



Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах.



Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суурь дэд бүтцийг өргөтгөж, иргэдийн ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах, ажлын байраар хангах, хүний хөгжлийг дэмжих замаар нийгмийн харилцааг хөгжүүлэх.





Удирдлага зохион байгуулалт

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) удирдан зохион байгуулж ажиллана.
- Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.
- Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бүс нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллана.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;
Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;
Бусад.



Үйл ажиллагааны тэргүүлэх дараах чиглэл баримтлана

1. Амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт татах чиглэлд идэвх санаачлага гаргах;
2. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;
3. Боловсрол, эрүүл мэндийг салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
4. Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон сурталчлах; үйлдвэрлэл, аялал жуулчлал гэх мэт бодит хөрөнгө оруулалт оруулах салбараа эрэмбэлэн хөгжүүлэх, иргэдийн тогтмол орлого олох боломжийг эрэлхийлэх;
5. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, тэднийг аймаг орон нутагт шилжин ирж суурьшин амьдрах сэдлийг төрүүлэх, хандлагыг өөрчлөх, амьдрах таатай орчин бүрдүүлэх, мэдээллээр хангах чиглэлд аймаг, орон нутаг манлайлан оролцож, эдгээрт чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулж тогтмолжуулах;
6. Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад тавих хяналтыг нэмэгдүүлэх




Хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:



Аймаг, орон нутгийг сурталчлах, уулзалт, зөвлөгөөн, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдээлэл хүргэх.




Баянтал суманд боловсруулах үйлдвэр, тээвэр логистикийн төв байгуулахыг бодлогоор дэмжих.



Сүмбэр суманд Чойр өртөөг өргөтгөж, авто болон төмөр замд тулгуурласан тээвэр логистикийн төв байгуулах ажлыг судалж, бодлогоор дэмжих

Автозамыг түшиглэн авто үйлчилгээний төв, гүний гааль байгуулах, транзит тээврийн үйл ажиллагааг дэмжих.



Орон нутагт бүртгэлтэй, үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагааг үргэлжлүүлэх, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.



Улаанбаатар хотод бүртгэлтэй боловч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн салбарыг орон нутагт татвар төлөгчөөр бүртгэх.

Баянтал суманд цэргийн анги шилжүүлэн байршуулахыг бодлогоор дэмжих.



51

Орон нутагт ажиллаж, амьдарч байгаа боловч шилжин ирээгүй иргэдийг шилжүүлэх, бүртгэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:



Орон нутаг болон бүс нутгийг хүнсээр хангах, хүнсний зориулалтаар стандартад нийцсэн агуулах зоорийг нэмэгдүүлэх, хүнсний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх. /500 тн, 1000 тн, 2500 тн/



Орон нутагт уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, олборлолт, тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллах.



Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцах, мөн шилжин ирж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтан, мэргэжилтнүүдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэгийг үзүүлэх.



Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежийг дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэдэг шаталсан сургалттай болгож, шаардлагатай инженер техникийн ажилчдыг бэлтгэх боломжийг бүрдүүлэх.



Шивээговь суманд нүүрс химийн болон эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгоход бодлогоор дэмжих.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах зорилтын хүрээнд:



Таних тэмдэг

- Синий гэрээний гүйцэтгэлийн үндсэн урсгал
- Ариутгах татуургийн шинээр хийгдэх шугам 1
- Ариутгах татуургийн шинээр хийгдэх шугам 2
- Ариутгах татуургийн шинээр хийгдэх шугам 3
- Бусадын шугам

Чойр хотын болон Шивээговь, Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, суурьшлын бүсийг өргөтгөх, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг сайжруулах.



Дэд бүтцийг өргөтгөх, инженерийн байгууламжуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх.



Бизнес эрхлэгчид болон гарааны бизнесийг зээлийн болон газрын бодлогоор дэмжих

Хэрэгжүүлэх арга хэмжээ

6.3. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суурь дэд бүтцийг өргөтгөж, иргэдийн ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах, ажлын байраар хангах, хүний хөгжлийг дэмжих замаар нийгмийн харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:



Шилжин ирж байгаа иргэдийг орон сууцаар хангах зорилгоор хуучин 555 айлын орон сууцыг үе шаттай засварлах, шинээр 428 айлын орон сууц барих ажлыг төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлэх.



Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтыг сайжруулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.



Хүн амын өсөлттэй уялдуулан сургууль, цэцэрлэгийг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлж, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх. /2 ээлжээр 4267 хүүхэд суралцаж байна./

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг дэмжих.




Аймгийн хэмжээнд газар тариалангийн бүс нутгийг бий болгож газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих /7500га/



Хүн амын өсөлттэй уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадал, хүний нөөцийн хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.


Хүн амын тоо

Төлөвлөлт
2024 он I улирал




Хөдөлмөрийн насны
хүн амын тоо

Төлөвлөлт
2024. он I улирал




Дотоодын нийт
бүтээгдэхүүн

Төлөвлөлт
2024 он I улирал




ДНБ-д эзлэх аж үйлдвэрийн
бүтээгдэхүүний хувь

Төлөвлөлт
2024 он I улирал




Татвар төлөгч аж
ахуйн нэгжийн тоо

Төлөвлөлт
2024 он I улирал



Төсвийн орлого

Төлөвлөлт
2024 он I улирал




Улсаас
татаас авах

2022 ОН




Шилжиж ирсэн иргэдийн, тоо

Төлөвлөлт
2024 он I улирал




Шинээр бий болсон
байнгын ажлын байр,
тоо

Төлөвлөлт
2024 I улирал



Шинээр бий болсон
түр ажлын байр, тоо

Төлөвлөлт
2024 он I улирал





ГОВЬСҮМБЭР АЙМАГТ ТАВТАЙ МОРИЛ.

Амьдралын ая
тухтай, цэвэр
цэмцгэр, төрийн
үйлчилгээ авахад
хүндрэлгүй, залуу,
эрч хүчтэй аймаг

Анхаарал тавьсанд
баярлалаа

www.govisumber.gov.mn
+976 7054-3434